ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р бэг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208 Цахим шуудан: dundgovi@audit.gov.mn

2022.03.25 № 91

танай ____________ -ны № ____________ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГА
С.АМАРСАНАА ТАНАА

# АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

0012020916

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ДУА-2022/15/НА-СТА-ТТЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Мандалговь хот<br>2022 он | Дарга,тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох<br>Утас: 70592439<br>Цахим хаяг: Munkhtogtokh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Х.Наранцацрал<br>Утас: 70592225<br>Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Т.Батсайхан<br>Утас: 70593113<br>Цахим хаяг: batsaikhant@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.Аудитын санал дүгнэлт

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
[illegible] Сайнцагаан сум Дундговь аймаг 48000 Утас: 70592439, 70592208, 70592209, Цахим шуудан: [illegible]

2022.03.25 № 01

танай ______ -ны № ______ -т

**ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГА С.АМАРСАНАА ТАНАА**

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

0012029915

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

## Агуулга


1.Аудитын санал дүгнэлт ........ 2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 8
3. Аудитын тайлан ........ 10
3.1 Ерөнхий зүйл ........ 10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 10
3.4 Материаллаг байдал ........ 11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 13
3.8 Аудитын гол асуудал ........ 14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 14
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 15
4. Аудитын илрүүлэлт ........ 15
4.1 Албан шаардлага ........ 15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 16


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2020оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | 724,927.3 | 829,478.9 |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 3а, 3б | 140,719.3 | 284,288.4 |
| 32 | **БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | 4а, 4б | - | - |
| 33 | **АВЛАГА** | 5а, 5б, 6а, 6б | 289,773.4 | 184,907.4 |
| 34 | **УРЬДЧИЛГАА** | 7а, 7б | - | - |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 8а, 8б, 8в | 294,434.6 | 360,283.1 |
| 36 | **НӨӨЦИЙН БАРАА** | 9а | - | - |
| 360 | **БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | 10 | - | - |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | 4,420,355.6 | 6,212,307.7 |
| 37 | **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | 11а, 11б | - | - |
| 37100 | **Урт хугацаат хадгаламж** | | - | - |
| 37200 | **Үнэт цаас** | | - | - |
| 37300 | **Урт хугацаат зээл** | | - | - |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 12а, 12б, 12в | 4,420,355.6 | 6,212,307.7 |
| 39200 | **Биет хөрөнгө** | | 4,309,799.0 | 6,101,682.3 |
| 39300 | **Биет бус хөрөнгө** | 13 | 110,556.7 | 110,625.4 |
| 39400 | **Бусад хөрөнгө /ТӨҮГ/** | 14 | - | - |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | | 5,145,283.0 | 7,041,786.6 |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | 28,241.0 | 20,950.3 |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 15а, 15б | 28,241.0 | 20,950.3 |
| 41100 | **Богино хугацаат үнэт цаас** | | - | - |
| 41200 | **Богино хугацаат зээлийн өглөг** | 16а, 16б | - | - |
| 41300 | **Өглөг** | 17а, 17б | 28,241.0 | 20,950.3 |
| 41400 | **Урьдчилж орсон орлого** | 18а, 18б | - | - |
| 42 | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | | - | - |
| 42100 | **Урт хугацаат үнэт цаас** | 19 | - | - |
| 42200 | **Урт хугацаат зээл** | 20а, 20б | - | - |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | 5,117,042.0 | 7,020,836.3 |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | | 5,117,042.0 | 7,020,836.3 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | 2,274,579.2 | 2,274,579.2 |
| 51200 | **Хуримтлагдсан үр дүн** | | 1,598,810.2 | 3,502,604.5 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 1,243,652.6 | 1,243,652.6 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | | 5,145,283.0 | 7,041,786.6 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан**

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2020оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | | 3,041,398.1 | 4,682,885.9 |
| 11 | **ТАТВАРЫН ОРЛОГО** | | 33,443.1 | 86,321.6 |
| 110 | **Орлогын албан татвар** | | 19,360.8 | 15,620.7 |
| 1100 | **Хувь хүний орлогын албан татвар** | | 19,360.8 | 15,620.7 |
| 113 | **Хөрөнгийн албан татвар** | | 778.0 | 38,886.5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | | 13,304.3 | 31,814.4 |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 1а, 1б | 431,867.9 | 2,496,787.5 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 428,107.9 | 2,496,787.5 |
| 121 | Хөрөнгийн орлого | | 3,760.0 | 0.0 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | 2,576,087.1 | 2,099,776.7 |
| II | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | 2а, 2б | 2,824,078.6 | 2,696,984.9 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | 2,824,078.6 | 2,696,984.9 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 2,085,985.9 | 2,618,609.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 1,126,805.7 | 1,180,442.1 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 139,122.8 | 150,770.8 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 168,029.6 | 185,571.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 86,346.2 | 220,323.7 |
| 2105 | Норматив зардал | | 73,086.1 | 256,975.4 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 32,370.6 | 15,524.7 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 13,709.5 | 13,345.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 20,405.8 | 8,967.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 426,109.6 | 586,690.1 |
| 211 | **ХҮҮ** | | 0.0 | 0.0 |
| 212 | **ТАТААС** | | 0.0 | 0.0 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 738,092.7 | 78,375.1 |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | 0.0 | 0.0 |
| III | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | | 217,319.4 | 1,985,900.9 |
| V | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | | 196,492.1 | 83,086.4 |
| VI | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | | 20,827.4 | 1,902,814.6 |

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|---|
| 1 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 5,098,286.4 | - | 5,098,286.4 |
| 2 | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | (2,071.8) | - | (2,071.8) |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 5,096,214.6 | - | 5,096,214.6 |
| 9 | **Тайлант үеийн үр дүн** | 20,827.4 | - | 20,827.4 |
| 10 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 5,117,042.0 | - | 5,117,042.0 |
| 11 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 5,117,042.0 | - | 5,117,042.0 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 979.8 | - | 979.8 |
| 13 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 5,118,021.8 | - | 5,118,021.8 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 1,902,814.6 | - | 1,902,814.6 |
| 20 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 7,020,836.3 | - | 7,020,836.3 |

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2020оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 2,718,100.6 | 2,293,639.8 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 33,443.1 | 86,321.6 |
| 110 | Орлогын албан татвар | 19,360.8 | 15,620.7 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 19,360.8 | 15,620.7 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 778.0 | 38,886.5 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 13,304.3 | 31,814.4 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 12,523.8 | 15,653.6 |
| 1181 | Газрын төлбөр | 780.6 | 1,360.8 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | - | 14,800.0 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 108,570.4 | 124,765.1 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 104,810.4 | 124,765.1 |
| 121 | Хөрөнгийн орлого | 3,760.0 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,576,087.1 | 2,082,553.0 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,518,644.7 | 2,012,215.9 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,518,644.7 | 2,012,215.9 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,780,621.0 | 1,931,974.6 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,127,093.5 | 1,179,952.6 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 139,194.4 | 150,770.8 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 168,029.6 | 185,631.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 81,858.9 | 89,558.1 |
| 2105 | Нормативт зардал | 57,010.0 | 155,993.1 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 98,415.6 | 18,304.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 13,709.5 | 13,345.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 23,016.6 | 12,177.1 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 72,292.9 | 126,242.8 |
| 211 | ХҮҮ | - | - |
| 212 | ТАТААС | - | - |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 738,023.7 | 80,241.4 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 199,455.8 | 281,423.8 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 104,728.5 | 137,854.7 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 104,728.5 | 137,854.7 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 104,728.5 | 137,854.7 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (104,728.5) | (137,854.7) |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | (56,000.0) | - |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 56,000.0 | - |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 38,727.3 | 143,569.1 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 101,991.9 | 140,719.3 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 140,719.3 | 284,288.4 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|---|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | **2,127,560.1** | **1,872,891.8** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | **1,870,282.8** | **1,802,852.3** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | **1,831,595.6** | **1,764,414.8** |

| | | | |
|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,163,397.5** | **1,153,488.7** |
| 210101 | Үндсэн цалин | 775,393.5 | 761,393.1 |
| 210102 | Нэмэгдэл | 301,030.3 | 299,134.5 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,764.0 | 3,662.0 |
| 210104 | Урамшуулал | 83,209.7 | 89,299.1 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **151,689.1** | **149,508.1** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 105,336.6 | 104,142.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,325.3 | 12,180.9 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,406.7 | 9,119.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,225.5 | 2,233.2 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 22,395.0 | 21,832.6 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **180,329.7** | **179,578.4** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,726.5 | 11,975.6 |
| 210302 | Түлш, халаалт | 167,103.2 | 167,102.8 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 500.0 | 500.0 |
| 210304 | Байрны түрээс | - | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **77,871.3** | **77,692.6** |
| 210401 | Бичиг хэрэг | 6,062.4 | 6,050.4 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 41,457.4 | 41,454.4 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,894.1 | 4,748.1 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,862.0 | 1,852.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 10,162.0 | 10,156.3 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 13,433.4 | 13,431.3 |
| **2105** | **Норматив зардал** | **73,944.5** | **54,746.8** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 31,921.7 | 18,700.0 |
| 210502 | Хоол, хүнс | 34,675.4 | 28,699.7 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 7,347.4 | 7,347.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **39,628.8** | **39,589.2** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 24,287.3 | 24,265.2 |
| 210602 | Тавилга | 3,250.0 | 3,250.0 |
| 210604 | Урсгал засвар | 12,091.5 | 12,074.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **13,495.0** | **13,345.0** |
| 210702 | Дотоод албан томилолт | 13,495.0 | 13,345.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **7,599.5** | **7,219.9** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,542.1 | 3,542.1 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 486.0 | 486.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 456.6 | 383.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 131.0 | 131.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,470.1 | 1,470.1 |
| 210807 | Газрын төлбөр | 813.7 | 513.6 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 700.0 | 694.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **123,640.2** | **89,246.0** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 118,208.7 | 83,815.4 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,431.5 | 5,430.6 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **38,687.2** | **38,437.5** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **38,687.2** | **38,437.5** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 27,155.4 | 26,907.8 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,830.0 | 5,827.9 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **167,277.3** | **70,039.5** |
| 223001 | Бусад хөрөнгө | 167,277.3 | 70,039.5 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **90,000.0** | - |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 90,000.0 | - |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,127,560.1** | **1,988,842.3** |

| | | | |
|---|---|---|---|
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,214,534.7** | **1,199,864.9** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | - | - |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,118,612.7 | 1,103,942.9 |
| 310004 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 95,922.0 | 95,922.0 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **691,561.8** | **686,987.4** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 691,561.8 | 686,987.4 |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | - | - |
| **33** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **21,907.3** | **8,690.3** |
| 330002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 21,907.3 | 8,690.3 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **199,556.3** | **93,299.6** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 70,000.0 | 58,980.5 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 31,000.0 | 34,319.0 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 98,556.3 | - |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 118,290.0 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 234,240.6 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Нэмэлт санхүүжилтийн тайлан**

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | ТЗ цэвэр дүн |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **275,714.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **275,714.0** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **248,581.7** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | **26,463.9** |
| 210104 | Урамшуулал | | 26,463.9 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | **1,262.7** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 846.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 103.9 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 83.1 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 20.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 207.9 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | **6,052.6** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 392.7 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 5,659.9 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **14,585.2** |
| 210401 | Бичиг хэрэг | | 1,584.6 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 3,796.0 |
| 210404 | Ном, хэвлэл | | 2,770.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 1,900.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 4,534.6 |
| **2105** | **Нормативт зардал** | | **101,246.3** |
| 210501 | Эм, болдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 97,948.1 |
| 210502 | Хоол, хүнс | | 3,298.2 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **31,744.9** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 25,744.9 |
| 210604 | Урсгал засвар | | 6,000.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **7,957.2** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 7,607.2 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 350.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **59,268.9** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 59,068.9 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 200.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **27,132.3** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | **25,906.8** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | 25,200.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 706.8 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **1,225.5** |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | | 1,225.5 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **306,769.1** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **306,769.1** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 16,188.5 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 73,381.0 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 21,178.3 |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | | 196,021.3 |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | **31,055.0** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 0.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 31,055.0 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор Т.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 01/36 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дундговь аймгийн Сайхан-Овоо сум нь эрхэм зорилгоо "Ардчиллыг бэхжүүлэн, нийгмийн өөрөө удирдах ёсыг төлөвшүүлж, сумын нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн өргөн оролцоотойгоор шийдвэрлэн, тэдний нөөц боломжийг дайчлах замаар орон нутгийн тогтвортой, тэнцвэртэй хөгжлийг хангахад оршино." гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг анч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд 2021 онд ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй, өгөгдсөн зөвлөмж байхгүй.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зориулалтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,696,984.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 26,969.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 18,878.9 мянган төгрөгөөр тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

#### *3.5.1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын 2021 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,896,503.7 мянган төгрөгөөр буюу 36.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.*

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 140,719.2 | 284,288.4 | 143,569.2 |
| Авлага | 289,773.4 | 184,907.4 | (104,866.0) |
| Урьдчилгаа | - | | |
| Бараа материал | 294,434.7 | 360,283.1 | 65,848.4 |
| Үндсэн хөрөнгө | 4,420,355.6 | 6,212,307.7 | 1,791,952.1 |
| **Нийт хөрөнгө** | **5,145,282.9** | **7,041,786.6** | **1,896,503.7** |
| Өр төлбөр | 28,241.0 | 20,950.3 | (7,290.7) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 5,117,041.9 | 7,020,836.3 | 1,903,794.4 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **5,145,282.9** | **7,041,786.6** | **1,896,503.7** |

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 143,569.2 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний зардлыг 167,277.3 мянган төгрөгөөр төсөвлөсөн болович цар тахлын улмаас хил хаагдаж бараа бүтээгдэхүүний үнэ өссөн, зарим үйл ажиллагаа хязгаарлаж байснаас цаг хугацааны хувьд хойшлогдсон зэргээс шалтгаалан 70,039.5 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан, түүнчлэн Сум хөгжүүлэх сангийн төсвийн эх үүсвэрийг хуримтлуулж сумын бодлоготой уялдуулан томоохон хэмжээний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор тайлант онд зээл олгоогүй зэрэг нь нөлөөлсөн.

Авлагын дансны үлдэгдэл 104,866.0 мянган төгрөгөөр буурсан. Энэ нь өмнөх оны эцэст цар тахлын хөл хориотой холбоотой төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгө тайлант онд нийлүүлэгдэж Сургууль, Цэцэрлэгийн дансны авлага буурсан. Мөн Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 54,058.7 мянган төгрөгөөр, Мал хамгаалах сангийн өвс тэжээлийн авлага 8,303.5мянган төгрөгөөр тус тус буурсан.

Бараа материалын үлдэгдэл 65,848.4 мянган төгрөгөөр өссөн нь цар тахлын эм тариа, вакцин, вакцинжуулалтын ажлыг зохион байгуулахад шаардагдах хамгаалах хэрэгслийг Эрүүл мэндийн төвд хүлээн авч бүртгэж тайлагнасантай холбоотой.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд улсын төсвийн хөрөнго оруулалтаар 1,507,758.1 мянган төгрөгийн барилга байгууламж, 32,890.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 67,815.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, ном худалдан авч, хандив болон бусад эх үүсвэрээс 562,047.6 мянган төгрөг, шилжүүлэн авсан 2,925.7 мянган төгрөгийн хөрөнго орлогод авч 49,417.0 мянган төгрөгийн хөрөнгө акталж, шилжүүлж данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,020,836.3 мянган төгрөг болж 1,903,794.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

### *3.5.2 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт*

Сайхан-Овоо сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 12 дугаар тогтоолоор Сайхан-Овоо сум тайлант онд 103,378.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 117,787.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 113.9 хувьтай биелүүлсэн байна.

*Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого* */мянган төгрөг/*

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **Татварын орлого** | | | | |
| Хувь хүний орлогын албан татвар | **12,730.0** | 13,480.7 | 750.7 | 105.9 |
| Бууны албан татвар | 800.0 | 750.0 | (50.0) | 93.7 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 1,450.0 | 1,426.0 | (24.0) | 98.3 |
| Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 875.0 | 1,542.5 | 667.5 | 176.3 |
| Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 7,348.0 | 14,800.0 | 7,452.0 | 201.4 |
| Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого | | 2,140.0 | 2,140.0 | - |
| Газрын төлбөр | 1,000.0 | 1,360.7 | 360.7 | 136.0 |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 11,625.0 | 12,685.1 | 1,060.1 | 109.1 |
| Мал тоолуулах албан татвар | 39,450.0 | 38,136.5 | (1,313.5) | 96.7 |
| **Дүн** | **75,278.0** | **86,321.5** | **11,043.5** | **114.7** |
| **Татварын бус орлого** | | | | |
| Хадгаламжийн хүүгийн орлого | 25,100.0 | 27,901.4 | 2,801.4 | 111.2 |
| Торгуулийн орлого | 3,000.0 | 3,564.1 | 564.1 | 118.8 |
| **Дүн** | **28,100.0** | **31,465.5** | **3,365.5** | **112.0** |
| **Нийт дүн** | **103,378.0** | **117,787.0** | **14,409.0** | **114.0** |

Ангийн нөөцийн орлого жилийн төлөвлөгөөнөөс 7,452.0 мянган төгрөгөөр давж биелсэн нь ангийн зөвшөөрлийг төлөвлөсөн хэмжээнээс илүү олгосонтой холбоотой байна.

Малын тоо толгой албан татвар 1,313.5 мянган төгрөгөөр тасарсан нь байгалийн гамшгаас шалтгаалан малын тоо толгой буурсантай холбоотой байна.

Бууны албан татвар 50.0 мянган төгрөгөөр тасарсан шалтгаан нь бүртгэлтэй буу ашиглалтаас хасагдсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Сайхан-Овоо сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар тогтоолоор сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,089,794.5 мянган төгрөгөөр, нийт зардлыг 2,089,794.5 мянган төгрөгөөр төлөвлөж доод шатны төсөв захирагчид хүргүүлж батлуулсан байна. Мөн ИТХ-ын 2021 оны 21 дугаар тогтоолоор 33,047.0 мянган төгрөг, 2021 оны 26 дугаар тогтоолоор 4,715.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн батлуулж ажилласан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрийн 40 арга хэмжээг санхүүжүүлэхээр урсгал зардалд 1,870,282.8 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 167,277.3 мянган төгрөг, эргэж төлөгдөх зээлд 90,000.0 мянган төгрөг, нийт зардлыг 2,127,560.1 мянган төгрөгөөр төлөвлөж баталжээ.

Нийт зардлын 1,214,534.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 691,561.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 21,907.3 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, урьд оны үлдэгдлээс 98,556.3 мянган төгрөгийг, 101,000.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 1,199,865.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 686,987.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 8,690.3 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 93,299.6 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос тус тус төвлөрүүлж, нийт 1,988,842.3 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн.

Үүнээс 1,802,852.3 мянган төгрөгийг урсгал зардалд, 70,039.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулж 1,872,891.8 мянган төгрөг буюу 88.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан. Нийт зардлын 69.6 буюу ихэнх хувийг ажиллагсадтай холбоотой зардал эзэлж байна.

Санхүүжилтээс дутуу зарцуулсан 14,669.7 мянган төгрөгийг улсын төсөвт, 3,262.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 73,381.0 мянган төгрөг, хандиваар 16,188.5 мянган төгрөг, төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны орлогоос 21,178.3 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын нэмэлт орлогоос 196,021.3 мянган төгрөг, нийт 306,769.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Цалин, НДШ-ийн зардалд 37,726.6 мянган төгрөг, байр ашиглалтын зардалд 6,052.6 мянган төгрөг, хангамжийн бараа материалын зардалд 14,585.2 мянган төгрөг, нормативт зардалд 101,246.3 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 21,744.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөрт 7,957.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 59,268.9 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 27,132.3 мянган төгрөг, нийт 275,714.0 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 1,225.5 мянган төгрөгийг төвлөрүүлж, эмнэлгийн нэмэлт санхүүжилтийн дансанд 31,055.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,612,758.1 мянган төгрөгийн гүүрний барилга, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 8,057.6 мянган төгрөгийн худаг, 19,600.0 мянган төгрөгийн хогийн цэгийн тохижилт, Зах зээл ба бэлчээрийн удирдлага төслөөс 58,139.0 мянган төгрөгийн худаг, 22,894.1 мянган төгрөгийн мал угаалгын ванн орлогдож авсан. Уг хөрөнгүүдийн худалдан авах ажиллагааг дээд шатны байгууллага зохион байгуулан худалдан авч шилжүүлсэн байна.

Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтэд байгалийн гамшигт үзэгдэлтэй холбоотой малчдад туслах 21,125.5 мянган төгрөгийн хандив орж ирснээс 18,584.5 мянган төгрөгийг гамшигт нэрвэгдсэн малчдад хандив, шатахууны зардалд 2,541.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Коронавируст халдварын цар тахалтай тэмцэх арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн яамнаас эм, эмийн хэрэглүүдийг аймгийн ЭМГ-аар дамжуулан хуваарилсан байна.
Хуваарилсан эмийн нэг бүрийн үнийг оронгийн цэг, таслалын алдаанаас 10 дахин өсгөж илүү нэхэмжилсэн 90 ширхэг эмийн үнийн зөрүү 1,158.2 мянган төгрөгийн, тусгай зориулалтын материалын 6,200.4 мянган төгрөгийн орлогыг бараа материалын дансанд бүртгэсгүй алдааг тус тус аудитын явцад залруулсан.

### 3.8 Аудитын гол асуудал

Сайхан-Овоо сумын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар хэвийн бус ажил гүйлгээ гараагүй.

Харин удирдлага зохион байгуулалтын хувьд доголдолтой, дотоод хяналт хангалттгүй аудитор өндөр шүүмжлэлтэй хандаж буй эрсдэлтэй асуудал нь аймгийн Эрүүл мэндийн газраас нийлүүлсэн эм, эмнэлгийн хэрэгслийн орлогыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, зарцуулалтад хяналт тавиагүй асуудал байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг дарга нь 2021 онд нийт 153 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулснаас 23 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 292 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Аж ахуйн харилцааны дүрэм" зөрчсөн зөрчлүүдийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын төсвийн шууд захирагч нарт 2,835.1 мянган төгрөгийн төлбөрийн 5 акт тогтоож, 39,149.4 мянган төгрөгийн зөрчил арилгах 14 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн бөгөөд хэрэгжилт дараах байдалтай байна.

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Биелэгдээгүй | | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 5 | 2,835.1 | 5 | 2,835.1 | | | 100 |
| Албан шаардлага | 14 | 39,149.4 | 14 | 39,149.4 | | | 100 |
| Зөвлөмж | 1 | | 1 | | | | 100 |
| Нийт | 19 | 41,984.5 | 19 | 41,984.5 | | | **100** |

Мөн тайлант оны санхүүгийн тайлангийн эцсийн аудитаар Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв, Цэцэрлэг, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сангууд хамрагдаж нийт 102,826.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн.

Аудитын явцад 97,686.5 мянган төгрөгийн алдааг залруулж, зөрчлийг арилгуулахаар 5,140.3 мянган төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлж албан бичгээр хариу ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн байгууллагуудын шатахуун, хүнсний материал, Эрүүл мэндийн төвийн эмийн зарцуулалтад дараагийн эцсийн аудитаар горим, сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад дүгнэлт гаргаж, 7 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Цэцэрлэгийн санхүүгийн тайланд "Зөрчилгүй" санал дүгнэлт өгсөн байна.

*Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал.*

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 128,179.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 119,056.1 мянган төгрөгийн 11 алдааг аудитын явцад залруулж, 9,123.1 мянган төгрөгийн 8 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 19.6 хувийг залруулагдаагүй, 80.4 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Алдаа зөрчлийг ангиллаар нь харуулбал ихэнх буюу 122,387.4 мянга буюу 80.4 хувь нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай, 29,732.8 мянган төгрөг буюу 19.6 хувь нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил тус тус илэрсэн байгаа нь дотоод хяналтыг сайжруулан нягтлан бодогч нарын ур чадвар, хариуцлагыг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

### 4.1 Албан шаардлага

Мал хамгаалах сангийн 23,941.0 мянган төгрөгийн насжилт өндөртэй хувь хүнээс авах авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д */дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах:/*, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д */ төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх. /* заасныг тус тус зөрчсөн байна.

***Шийдвэрлэсэн нь:*** *Дээрх зөрчлийг дахин давтан гаргуулахгүй байхаар 23,941.0 мянган төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.*

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:** | | | | | | | | | | | |
| 1 | ЗДТГ | 1 | | | | | | 1 | | | |
| 2 | ЭМТ | 1 | 2,855.6 | | | | | 1 | 2,855.6 | | |
| 3 | ЕБС | 1 | | | | | | 1 | | | |
| 4 | МХС | 1 | 23,941.0 | | | | | 1 | 23,941.0 | | |
| | **дүн** | **4** | **26,796.6** | | | | | **4** | **26,796.6** | | |
| **2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:** | | | | | | | | | | | |
| 1 | ЗДТГ | 4 | 16,646.4 | 2 | 13,025.4 | | | 2 | 3,621.0 | | |
| 2 | ЭМТ | 5 | 10,157.0 | 3 | 7,545.0 | | | 2 | 2,612.0 | | |
| 3 | ЕБС | 1 | 110.8 | 1 | 110.8 | | | | | | |
| 4 | ЦЭЦЭРЛЭГ | 2 | 579.3 | 1 | 544.8 | | | 1 | 34.5 | | |
| 5 | СОЁЛЫН ТӨВ | 3 | 330.0 | 3 | 330.0 | | | | | | |
| 6 | ОНХС | 1 | 97,500.0 | 1 | 97,500.0 | | | | | | |
| | **дүн** | **16** | **125,323.5** | **11** | **119,056.0** | | | **5** | **6,267.5** | | |
| | **Нийт зөрчлийн дүн** | **20** | **152,120.1** | **11** | **119,056.0** | | | **9** | **33,064.1** | | |